# ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Д.Мөнхбүрэн

2011.02.18
Улаанбаатар хот

# Таны эрхийн хамгаалалт

Үндсэн хууль

Хууль

Хууль чилсан акт

Олон улсын эрх зүйн акт

Хуулийн тайлбар

# Үндсэн хууль

- 16.16. Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй.
- 16.17. Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар **мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй**.

# Үндсэн хууль

- 10 дугаар зүйл.

10.3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соcрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.

10.4. Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй.

# Олон улсын эрх зүйн акт



<u>Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, XIX зүйл</u>

“Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй: энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч саадгүй  баримтлах эрх чөлөө, үэзл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана”

# Олон улсын эрх зүйн акт

Иргэний болон Улс төрийн Эрхийн тухай Олон Улсын Пакт, 19-р зүйл, 1974

1. Хүн бүр үзэл бодлоо ямарч хорио саадгүй баримтлах эрхтэй
2. Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр, эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана

# Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль, 1998

- ОНМХ нийтэлж, нэвтрүүлсэн зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ
- Аливаа хэлбэрийн хяналтыг хориглоно
- Төр ОНМХ өмчлөхгүй
- УИХ хэвлэлийн эрх чөлөөг хязгаарласан хууль гаргахгүй

## Олон нийтийн радио, телевизийн тухай хууль

2005

- Өмч, удирдлага, санхүүжилт, хяналт
- Редакцийн хараат бус байдал
- Иргэний хариу өгөх эрх
- Өөрийн зохицуулалтын механизм
- Сэтгүүлчийн мэдээлэл олж авах эрх
- Мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрх
- Орон нутгийн ОНӨН-ийг зохицуулах оролдлого

## Зар сурталчилгааны тухай хууль, 2002

*Зүйл 3.1.5*

*“Мэдээлэх хэрэгсэл” гэж телевиз, радио, холбооны шугам сүлжээ, компьютерийн сүлжээ, тусгай программ, хэвлэл болон бусад арга хэрэгсcэл” гэсэн утгаар ойлгоно.*

## Холбогдох хуулиуд

- Радио долгионы тухай хууль,1999
- Харилцаа, холбооны тухай хууль, 2001
- Улсын бүртгэлийн тухай хууль, 2009
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, 2003
- Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Бүх шатны сонгуулийн тухай хууль, Сонгуулийн төв байгууллагын тухай хууль
- Бусад хууль (Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль гэх мэт

# Хуульчилсан акт

- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай "  УИХ-ын тогтоол №103, 1998.8.28
- Дээд шүүхийн тайлбар: Эрүүгийн хууль, 139, 110,111
- Долгион, харилцааны холбооны тухай хуультай холбоотой 17 дүрэм, журам
- Бусад: тогтоол, тушаал, захирамж г.м

# ЗӨӨЛӨН ХЭМ ХЭМЖЭЭ

Мэдээллийн эрх чөлөө нь хүний язгуур эрх бөгөөд…НҮБ-аас эрхэмлэдэг хүний бусад эрхийн үндсэн хэмжүүр мөн

НҮБ-ын Ерөнхий ассемблейн анхдугаар чуулга уулзалтын 59-р тогтоолоос

# ЗӨӨЛӨН ХЭМ ХЭМЖЭЭ

- “Чөлөөт хэвлэл бол чөлөөт ард иргэд мөн” “, Чөлөөт хэвлэлийн харти, 1987
- “Хэвлэлийн эрх чөлөө гэж хөндлөнгийн нөлөө, дарамт шахалтаас ангид байхыг хэлнэ”- Ардчилсан хэвлэл мэдээллийн соёлын тунхаг, ОУСХ
- Хараат бус хэвлэл гэж засгийн газар, улс төр, эдийн засгийн хяналт, мөн материал, үйлдвэрлэл, түгээлтийн дэд бүтцээс хараат бус байхыг хэлнэ” - Уэндхүекийн зарчим, ЮНЕСКО, ОУСХ
- Сэтгүүлчдийн баримтлах зарчим, МСНЭ, 2005

# Хэм хэмжээний агуулгаар:

- Эрх чөлөөг баталгаажуулсан
- Сэтгүүлчийн үйл ажиллагаа
- Агуулга
- Зарим мэдээлэл нээлттэй байх
- Хэрэгслийг зохицуулсан
- Хязгаарласан

# Хязгаарлалт: ИБУТЭОУП-19

- Бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх
- Үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах

# Бодит байдал-Хязгаарлалт

Үзэл бодлоо илэрхийлэх, мэдээллийн эрх чөлөөнд нөлөөлж буй Монголын улсын хууль тогтоомж, 2001

- 232 хууль
- 91 – хуулийн зүйл заалт
- 51 нь хязгаарлалт

2007 оны судалгаа

- 360 хууль
- 120 буюу 33%- мэдээлэл нээлттэй байх
- Хязгаарласан хуулийн тоо нэмэгдэж буй

# Хязгаарлалт тогтоож буй хуулиуд

- Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалтын тухай хууль
- Байгууллагын нууцын тухай хууль
- Бусад хууль

# Хязгаарлалт

***Нэр төр гутаах***

- **Иргэний хууль**, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд
- **Эрүүгийн хууль**, 110,111, гүтгэлэг, доромжлол, 2008 онд нэмэлт өөрчлөлт орсон

# Хамгаалалт: 139 дүгээр зүйл /ЭХ/

Сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад хийх



Өөрийн болон бусдын ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг нийтэд тараах, эсхүл тараалгахгүй байхын тулд

# Сэтгүүлч гэж хэн бэ?

- Бүтэн буюу хагас цагаар сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхэлж байгаа хүн.
- Үүнд эзний хөлсөлөн авсан эрхлэгч, ер.редактор, сурвалжлагч, фото сурвалжлагч, зураглаач, эх бэлтгэгч, найруулагч зэрэг бүгд хамаарна.

/ОУСХ/



Мэдээ, мэдээлэл цуглуулах, боловсруулах, нийтлэх, нэвтрүүлэх үйл ажиллагааг сэтгүүл зүйн үйл ажиллагаа гэнэ.

# “сэтгүүлчийн хуульд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаа…”

- Үндсэн хууль болон бусад хуулиар хамгаалагдсан төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотойгоос бусад мэдээллийг хайх, хүлээн авах, цуглуулах, боловсруулах, нийтлэх ажиллагааг хэлнэ. /УДШ/

- “…саад хийсэн…” гэдэгт сэтгүүлчээс хуульд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулах боломжгүй байдалд хүргэсэн, эсхүл үндэслэл бүхий шалтгаангүйгээр хүндрэл учруулсан аливаа үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.
Энэ нь сэтгүүлчийн үйл ажиллагааг хууль бусаар хязгаарлах, зогсоох, хяналт тогтоох, мэдээлэл олох боломжийг хаах, олсон мэдээллийг хууль бусаар хурааж авах, устгах, өөрт нь болон ойр дотны хүмүүст хүч хэрэглэх, нэр төр, алдар хүндийг нь гутаасан мэдээ баримт тараах буюу эд хөрөнгийг нь устгахаар заналхийлэх, албан тушаал бууруулах буюу ахиулах амлалт өгөх, мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг зогсоох буюу хаах зэргээр илэрч болно. /УДШ/

# Анхаарал тавьсанд баярлалаа



www.globeinter.org.mn

Утас: 324627, 324764